


- Монгол орон нь хойд өргөргийн $41^{\circ}35'$ - $52^{\circ}09'$ хооронд оршдог бол хойд хэсгийн нутаг дэвсгэрийн газарзүйн зургийг зурахад хэд дүгээр өргөргийн дагуух нутгууд гажилтгүй зурагддаг вэ?
A. $X\Theta42^{\circ}$ B. $X\Theta45^{\circ}$ C. $X\Theta49^{\circ}$ D. $X\Theta52^{\circ}$
- Буриад ястнууд нь ихэвчлэн Дорнод, Хэнтий, Төв, Хөвсгөл, Сэлэнгэ аймгуудын нутгаар тархсан байдаг бол дараах зурагт хэд дугаараар тархалтыг тэмдэглэсэн байна вэ?

Монгол орны угсаатны тархалт



- A. 1
B. 2
C. 4
D. 6

- Монгол орны уулсын тогтолцооноос аль нь зүүн тийшлэх тутам говь маягийн шинжтэй болдог вэ?
A. Алтайн нуруу B. Хангайн нуруу
C. Хэнтийн нуруу D. Хөвсгөлийн уулс
- Монгол орны газар нутгуудаас аль галавын үеийн үлэг гүрвэлийн ул мөр хамгийн олон олдсон бэ?
A. Юра B. Пермь C. Триас D. Цэрд
- Элсэн чихэр, давс чийгтэх нь цаг агаарын ямар шинжийг илэрхийлэх вэ?
A. улирал сайхан болох шинж B. тэнгэр сайхан болох шинж
C. тэнгэр муудах шинж D. улирал хатуу болох шинж
- Монгол орны өвлийн уур амьсгалд аль бүсийн агаарын урсгал нөлөөлдөг вэ?
A. экватор B. арктик C. тропик D. субтропик
- Аль нь ус нэвтрүүлэх чадвар сайтай хөрс вэ?
A. хар шороон хөрс B. шавранцар хөрс
C. элсэнцэр хөрс D. хөнгөн шавранцар хөрс
- Монгол орны хамгийн өмнөд захын цэг болох Орвог гашууны бор толгойд өвөл болон зуны улиралд нар мандах, жаргах үеийн хугацааг хүснэгтэд харуулав. Тухайн газар нутагт өвөл болон зуны улирлын өдрийн урт нь хэдэн цагийн зөрүүтэй байх вэ?

Байршил	Улирал	Нар мандсан цаг	Нар жаргасан цаг	Өдрийн урт
Орвог гашууны бор толгой	Зун (VII/01-нд)	05 цаг 29 минут	20 цаг 39 минут	?
	Өвөл (XII/25)	08 цаг 25 минут	17 цаг 35 минут	?

- A. 15 цаг 10 минут B. 9 цаг 10 минут
C. 00 цаг 08 минут D. 6 цаг 00 минут
- Манай улсын хамгийн жижиг нутаг дэвсгэртэй аймаг бол 5540 км^2 талбай бүхий Говьсүмбэр аймаг юм. Уг аймаг нь 2024 оны байдлаар 3 сум, 10 багт нийт 5265 өрхийн 18159 хүн ам оршин суугаа байгаа бол хүн амын нягтшилыг тооцоолж олоорой.
A. 0.3 хүн/км^2 B. 0.9 хүн/км^2 C. 3.3 хүн/км^2 D. 0.01 хүн/км^2

10. Ашигт малтмалуудыг тохирох утгуудтай нь зөв харгалзуулсныг сонгоорой.

№	Ашигт малтмал	№	Төрөл	№	Орд газар
1	Алт	A	Металл бус	a	Бороо
2	Давс	B	Шатах	b	Цагаан Овоо
3	Шатах занар	C	Металл	c	Шүдэн уул

A. 1-C-a, 2-A-c, 3-B-b

B. 1-A-a, 2-B-b, 3-C-c

C. 1-B-a, 2-A-b, 3-C-c

D. 1-C-b, 2-A-a, 3-B-c

11. Дараах байгалийн нөхцөлд ямар хөрс үүсэх магадлал өндөр вэ?

(Голын сав газар + чийг их + ургамал өтгөн + үер усны нөлөө их)


A. Элсэрхэг хөрс – усыг сайн барьж шингээдэг тул ургамал өтгөн ургана.

B. Говийн саарал хөрс – хур тунадас бага тул хөрсөн дэх ялзмаг ихэснэ.

C. Нугын хөрс – чийг их, органик бодис хуримтлагдаж үржил шим сайжирна.

D. Уулын хөрс – чулуурхаг тул ус нэвтрүүлэх чадвартай чийг хуримтлагдана.

12. Цаг агаарын зургийн таних тэмдгийг ашиглан тухайн өдрийн цаг агаарын байдлыг тодорхойлсон хувилбарыг сонгоорой.



A. Тэнгэр цэлмэг бөгөөд үүлгүй, хуурайвтар, салхины хүч сул, агаарын даралт 859 гПа учир агаарын температур +23°C дулаан байна.


B. Тэнгэр бүрхэг, хур тунадас орох учир дулаан ба чийглэг, салхи зүүн өмнөдөөс дунд зэргийн хүчтэй, агаарын даралт 985.9 гПа – аас өсөх хандлагатай байна.

C. Бага зэрэг үүлтэй, ялимгүй хур тунадас орох учир сэрүүхэн, агаарын хэм 16°C байх бөгөөд салхи баруунаас хүчтэй салхилж, даралт тогтвортой байна.

D. Агаарын чийг 60% байх учир манантай, маш хүйтэн болж агаарын хэм 16 -23° хооронд хэлбэлзэлтэй, даралт огцом буурах төлөвтэй байна.

Зургийг ашиглан даалгаврүүдыг гүйцэтгээрэй.

Говийн нууруудын усны түвшин



13. Зураг дахь нууруудаас хамгийн гүн нуурыг сонгоорой.

A. Хяргас

B. Бөөнцагаан

C. Орог

D. Дуут

14. Нууруудын усны түвшин багасахад нөлөөлөх байгалийн хүчин зүйлийг сонгоорой.

A. усны хэт ашиглалт

B. уур амьсгалын өөрчлөлт

C. хүний үйл ажиллагаа

D. уул уурхайн олборлолт

15. Хэдэн оноос хойш нууруудын усны түвшин тогтмол багасаж эхэлсэн байна вэ?


A. 1993 он

B. 2011 он


C. 2017 он

D. 2002 он

16. Сутай хайрхан уулсын орчим дахь мөстлийн хэмжээ 2002 – 2023 оны хооронд хэрхэн өөрчлөгдсөн байгааг оновчтой тодорхойлсон хувилбарыг сонгоорой.




- A. Мөстлийн хэмжээ нь багасаж, ихэвчлэн уулын зах хэсгүүдэд хайлалт явагдсан байна.
B. Мөстлийн хэмжээ нь багасаж, ихэвчлэн баруун талын жижиг хэсгээр хайлалт явагдсан байна.
C. Мөстлийн хэмжээ нь багасаж, зөвхөн уулын хойд зах хэсгээр хайлалт явагдсан байна.
D. Мөстлийн хэмжээ нь багасаж, ихэвчлэн төвийн хэсгээр хайлалт явагдаж хил зааг үүссэн байна.
17. Сутай хайрхны мөсөн бүрхүүл цаашид багассаар байвал ямар эрсдэл үүсэх вэ?
A. Агаарын даралт буурч, амьсгалахад хүндрэл үүсэх нөхцөл бүрдэнэ.
B. Уулын өндөр багасаж, газар нутгийн талбайн хэмжээ нэмэгдэнэ.
C. Эх газрын хэмжээ нэмэгдэж, шинэ газар бий болох боломж бүрдэнэ.
D. Усны хомсдол үүсэж, гол мөрөн, нуурын усны хэмжээ багасна.
18. Нэгэн унтарсан галт уулын гадаргын хэлбэр ба өндрийг хаяалбараар тодорхойлсныг зургаар илэрхийлэв. Зургийг ажиглан галт ууланд үүссэн тогоог үзэхийн тулд аль талаас нь авиралт хийж хэдэн метрийн өндрөөс бүтэн харах тохиромжтой хувилбарыг сонгоорой.




- A. баруун хойд талаас нь авирч, 1400 метрээс харах.
B. өмнөд талаас нь авирч, 1200 метрээс харах.
C. зүүн хойд талаас нь авирч, 1400 метрээс харах.
D. зүүн талаас нь авирч, 1200 метрээс харах.

19. Зургийг ажиглан манай улсын 2024 онд хамгийн их тунадас унасан хэсгийг зөв тодорхойлсон хувилбарыг сонгоорой.



- A. Улаанбаатар хотод тунадасны хэмжээ хамгийн их буюу 500 – 550 мм зузаан тунадас унасан байна.
- B. Хөвсгөлийн уулсын зүүн өмнөд хэсгээр тунадас хамгийн ихээр унасан бөгөөд тогтмол 400 мм түүнээс их унасан байна.
- C. Хэнтийн уулс орчмоор 550 мм түүнээс дээш тунадас унасан байгаа нь хамгийн их утгыг илэрхийлж байна.
- D. Хэнтий аймгийн ихэнх нутгаар хамгийн их тунадастай буюу 450 – 550 мм зузаан тунадас унасан байна.
20. Телевизийн багийнхан Монгол орны өмнөд хилийн цэг Орвог гашууны бор толгой руу явж нэвтрүүлэг хийх болжээ. Тэд явахаасаа өмнө газарзүйн зураг ашиглан явах замын уртыг тооцоолж явсан боловч бодит явсан замын нийт урт 859 км болж, тооцоолсноос нь зөрүүтэй байдал үүссэн байна. Зөрүүтэй байдал үүсэхэд хэмжилтийн ямар ямар алдаа гаргасан байж болохыг сонгоорой.



- 1) Газрын зураг дээр хэмжсэн зам нь шулуун байсан ч бодит байдал дээр зам тахир, тойруу байдаг.
- 2) Ашигласан зураг нь газарзүйн зургийн конус тусгагийг ашигласан учир шугамаар хэмжихэд гажилт бага байж бодит зайтай яг таардаг.
- 3) Зөвхөн уртрагийн дагуу хэмжилт хийж 10^0 -д ногдох уртрагийн нумын уртыг ашиглан тооцоолол хийсэн тул алдаа гарсан.
- 4) Зэргэдийн 10^0 -д тулсан нумын уртыг ашиглан ХӨ47, ХӨ41 хоёрын зөрүүг олж тооцоолсон.
- 5) Газрын зураг дээр хоёр газрын хоорондох зайг буруу хэмжиж тооцооллоо алдсан.
- 6) Дэлхийн гадаргуу хотгор, гүдгэр боловч зураг дээр хавтгайд дүрсэлсэн тул зай гажилт үүсдэг.
- 7) Хоёр газрын зайг шулуунаар хэмжиж газрын зургийн масштаб ашиглан бодит зайг тооцоолоход 663 км гэж гаргасан нь бодит зайнаас зөрүүтэй байдал үүссэн.
- 8) Аяллын явцад хүмүүс илүү их юм үзэж явахын тулд тооцоолсон замын уртаас илүү явсан.